МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 24 өдөр Дугаар А/42 Улаанбаатар хот

Журам батлах тухай

ШУА-ийн Эрхзүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.1, 7.4.2 дахь заалт, ШУА-ийн дүрмийн 2 дугаар зүйлийн 5-ийн “а”, “е” дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд, судлаачдын эрхлэн гаргасан ном, бүтээлийг цахимаар худалдах “Цахимаар ном борлуулах журам”-ыг хавсралтын дагуу баталсугай.

2. Журмыг 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлж ажиллахыг Инноваци, мэдээллийн хэлтсийн дарга (*Д.Батхуяг*)-д даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Д.РЭГДЭЛ

D.Acad.2018 Tushaal4 sar.doc

ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2018 оны ...04 –р сарын ...24-ны өдрийн ...А/ тоот тушаалын хавсралт

УХАА0124 9087044

ЦАХИМААР НОМ БОРЛУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар “Номын өмчлөгч” болон “Номын борлуулагч” талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Уг журам нь “Номын өмчлөгч” номоо борлуулахаас өмнө хүлээн зөвшөөрч, баталгаажуулсны үндсэн дээр хэрэгжинэ.

1.3. Ном нь www.bookstore.ac.mn цахим хуудсаар худалдаалагдана.

ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Цахим номын худалдаагаар ШУА-ийн харъяа хүрээлэнгийн өмч, бүтээл болох номыг борлуулна.

2.2. ШУА-ийн хүрээлэнгээс номын худалдааг хариуцах мэргэжилтэн тухайн хүрээлэнгийн номын нөөц, төлбөр тооцоог хянаж ажиллана.

2.3. Тэргүүлэгчдийн газрын Аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн нь ШУА-ийн харъяа хүрээлэнгийн томилогдсон мэргэжилтэнд номын захиалга өгөх, бүртгэл хөтлөн хүлээн авах, худалдан авагчид баримтыг үндэслэн номыг хүлээлгэн өгөх, номын нөөцөд хяналт тавих ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО

3.1. Цахим номын худалдааны төлбөрийг Шинжлэх ухааны Академийн 5131186239 Хаан банкны дансанд төвлөрүүлнэ.

3.2. Худалдан авсан номоо ирж авах, эсвэл өөрийн хаягаар хүргүүлэх гэсэн 2 сонголтыг худалдан авагчид санал болгоно.

3.2.1. Худалдан авагч өөрөө номоо ирж авах тохиолдолд төлбөр төлсөн баримтыг үндэслэн, Тэргүүлэгчдийн газрын агуулахаас олгоно.

3.2.2. Худалдан авагч хаягаар хүргүүлэх тохиолдолд хүргэлтийн үйлчилгээний төлбөр төлж, номоо шуудангаар хүлээн авна.

3.3. ШУА-ийн хүрээлэнгийн томилогдсон мэргэжилтэн, Тэргүүлэгчдийн газрын Аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн нар хагас жилд 1 удаа номын тооцоогоо хийнэ.

3.4. Борлуулалтын орлогоос 10%-ийг үйл ажиллагааны зардалд суутгана. Үүнээс 1%-ийг системийн тогтвортой үйл ажиллагаанд, 1%-ийг Хаан банктай байгуулсан гэрээний дагуу, 8%-ийг бусад зардалд зарцуулна.

3.5. ШУА-ийн цахим номын дэлгүүрээр өөрийн бүтээсэн номыг борлуулах саналтай судлаачийн хүсэлтийг харьяалах Хүрээлэн нь хүлээн авч, борлуулалтын орлого хуваарилах гэрээ байгуулж болно.

ДӨРӨВ. БУЦААЛТ

4.1. Номын захиалга баталгаажиж, хүргэлтээр эсвэл өөрийн биеэр хүлээн авсны дараа худалдан авалтыг буцаахгүй.

4.2. Захиалсан номоо хүлээн авахаас өмнө захиалгаа цуцалбал номын үнийн дүнгийн 5 %-ийг систем болон үйл ажиллагаа, банкны шилжүүлэг зэрэг шимтгэлд суутгана.

4.3. Худалдан авалтаа хүргүүлэх сонголт хийсний дараа захиалга цуцлах бол хүргэлтийн төлбөрийг буцаан олгохгүй.

.....oOo.....